

**НЭМЭЛТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ  
№ НАҮ-РХАА 2022-20**

2022-04-27

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас **2699877** регистрийн дугаартай “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Г.Балжинням нөгөө талаас **2040433** регистрийн дугаартай “Бодь интернэшнл” ХХК /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Долгормаа /хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2017 оны “Нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам”-ыг үндэслэн Талууд дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- 1.1. Гүйцэтгэгч нь “Бодь интернэшнл” ХХК-ийн захиалгаар “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын цахилгаан хангамжийг Төвийн эрчим хүчний системтэй холбох үеийн реле хамгаалалтын тооцоог гүйцэтгэх /цаашид “Гэрээт ажил” гэх/, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ гэрээний зорилго оршино.
- 1.2. Энэ гэрээнд тусгагдаагүй бусад харилцааг Монгол улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Энэ гэрээний **Хавсралтад** “Бодь интернэшнл” ХХК-ийн захиалгаар “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын цахилгаан хангамжийг Төвийн эрчим хүчний системтэй холбох үеийн реле хамгаалалтын тооцоо Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4. Энэ гэрээгээр гүйцэтгэсэн гэрээт ажил нь Талуудын оюуны өмч болох тул гуравдагч этгээдэд дамжуулах болон ашиглуулах тохиолдолд нөгөө Талын зөвшөөрлийг заавал авна.

**ХОЁР. ГЭРЭЭТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА**

- 2.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлын төлбөрийг төлсөн өдрөөс эхлэн ажлын 45 /дөчин тав/ хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Захиалагчаас хамаарсан болон Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэнэ.

**ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТООЦОО**

- 3.1 Гэрээт ажлын нийт төлбөр нь татвар хураамж /НӨАТ/ багтсан нийт дүнгээр **29,480,000.00 (хорин есөн сая дөрвөн зуун наян мянга)** төгрөг байна.
- 3.2 Энэ гэрээний нийт төлбөрт Гүйцэтгэгчээс гэрээт ажлыг хийж гүйцэтгэх ажлын хөлс, шаардлагатай материал, ажилтны хөлс, бүх татвар, хураамж болон зардал багтсан болно.
- 3.3 Гэрээний төлбөрийг Захиалагч нь Гүйцэтгэгчид **29,480,000.00 (хорин есөн сая дөрвөн зуун наян мянга)** төгрөгийг төгрөгийг нэхэмжлэхийг үндэслэн, Худалдаа хөгжлийн банкны 406002860 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.4 Гүйцэтгэгч нь Захиалагч гэрээт ажлын төлбөрийг бүрэн төлсөний дараа НӨАТ-ын баримтын бичилт хийнэ.

**ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ТЭЗҮ, Нэгдсэн сүлжээтэй холбогдох схем, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын үндсэн тоноглолын өгөгдөл зэрэг бусад шаардлагатай мэдээллээр бүрэн хангана.
- 4.2 Хийгдэх ажлын хэмжээ өөрчлөгдөх, зогсоох шаардлага гарвал Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэх, гэрээнд заагдаагүй нэмэлт ажил гарвал Гүйцэтгэгчийн шаардлагыг хүлээн авч шийдвэрлэнэ.



- 4.3 Гүйцэтгэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас ажлыг зогсоох, анх өгсөн техникийн өгөгдөл, анхдагч хэлхээний зураг схемд өөрчлөлт орж ажлыг дахин хийх шаардлага гарвал холбогдох зардал, ажлын хөлсийг Гүйцэтгэгчид нэмж төлнө.
- 4.4 Захиалагч нь зураг төслийн болон бусад холбогдох норм дүрэм, стандартыг Гүйцэтгэгч зөрчсөн болон чанарын гологдол гаргасан нь тогтоогдсон тохиолдолд уг доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.
- 4.5 Захиалагч нь Гүйцэтгэгчээс гэрээт ажлын гүйцэтгэлийг албан тоот болон гэрээ дүгнэсэн актаар хүлээн авна.

#### **ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ**

- 5.1 Гүйцэтгэгч нь Захиалагчаас шаардагдах өгөгдөл, схем, мэдээллийг болон Захиалагчийн төлбөр төлсөн баримт зэргийг бүрэн хүлээн авсанаар гэрээт ажлыг эхэлнэ.
- 5.2 Гэрээт ажлыг холбогдох норм, дүрэм, стандартын дагуу чанартай гүйцэтгэж гэрээнд заасан хугацаанд багтаан Захиалагчид гэрээт ажлын гүйцэтгэлийг актаар хүлээлгэн өгнө.
- 5.3 Гэрээт ажлын явцад алдаа гарсан нь илэрч зураг төслийн ажлын явцад хүндрэл үүсгэвэл Гүйцэтгэгч өөрийн хүч хөрөнгөөр илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах үүрэг хүлээнэ.
- 5.4 Гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүн нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэгдсэн, техникийн нөхцөл, зургийн даалгаврыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд Захиалагчийн дахин тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгөөр мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэж гэрээт ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн актаар хүлээлгэн өгнө.
- 5.5 Захиалагчаас шилжүүлэн өгсөн аливаа баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 5.6 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд Захиалагчаас авсан техникийн үзүүлэлт, тооцоо, баримт материал зэргийг гэрээт ажил дууссаны дараа Захиалагчид хүлээлгэн өгнө.

#### **ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 6.1 Захиалагч төлбөрийг гэрээнд заасан журмаар төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алданги төлнө.
- 6.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гэрээний нийт үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.
- 6.3 Талуудын гэрээгээр хүлээсэн үүргээс үүсэх алданги төлөх дээд хэмжээ нь гэрээний нийт үнийн 10 %-аас хэтрэхгүй байна.
- 6.4 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг алдаатай алдаатай гүйцэтгэсний улмаас Захиалагчид хохирол учирсан тохиолдолд Гүйцэтгэгч нь үл маргах журмаар нөхөн төлнө.
- 6.5 Захиалагчийн буруугаас гэрээт ажлын гүйцэтгэл үр дүнгүй болж дахин горимын тооцоо хийх болсон тохиолдолд Захиалагч үл маргах журмаар Гүйцэтгэгчид дахин төлбөр төлнө.

#### **ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ**

- 7.1. Гүйцэтгэгч нь Захиалагчид гэрээт ажлыг албан бичгээр мэдэгдсэнээр энэ гэрээнд заагдсан хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно.
- 7.2. Талууд гэрээт ажлыг гэрээний гүйцэтгэлийг хүлээлцэх актаар баталгаажуулна.

#### **НАЙМ. БУСАД ЗҮЙЛ**

- 8.1 Гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал гаргасан Тал нь албан бичгээр нөгөө талдаа саналаа хүргүүлнэ. Хүлээн авсан Тал нь ажлын 5 хоногт хариуг албан бичгээр хүргэнэ.
- 8.2 Нэмэлт, өөрчлөлтийг Талууд харилцан зөвөөрсөн тохиолдолд тус өөрчлөлтийг гэрээнд бичгээр үйлдэж оруулах бөгөөд Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.



- 8.3 Энэ гэрээний нөхцлүүдийг зөрчсөн буюу гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 8.4 Гэрээнээс үүссэн маргааны зөвшилцөлийг эс зөвшөөрсөн Тал нь Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.5 Энэ гэрээг 2 /хоёр/ эх хувь үйлдэж, баталгаажуулах ба Талууд тус бүр нэг эх хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 8.6 Гэрээт ажлыг Талууд бүрэн хүлээлцэж, төлбөр тооцоог 100 хувь барагдуулсанаар гэрээ дуусгавар болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК:

Гүйцэтгэх захирал

..... Т.Балжинням

Тэргүүн дэд захирал бөгөөд

Ерөнхий диспетчер

..... Б.Баатар

Зах зээл, санхүү хариуцсан дэд захирал

..... Ц.Өнөрмаа

СЭЗА-ны дарга

..... Т.Бямбажав

РХАА-ны дарга

..... Ч.Амарсанаа

ЗЗЗА-ны дарга

..... Мөнхбат

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн

..... Ч.Отгонбаатар

Гэрээний мэргэжилтэн

..... Д.Алимаа

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэх захирал

..... Б.Долгормаа

Төсөл хариуцсан дэд захирал

..... Б.Эрдэнэбаяр

Санхүү хариуцсан захирал

..... В.Мягмаржав

Гүйцэтгэгчийн хаяг:

17032. Улаанбаатар хот  
 Хан-уул дүүрэг, Чингисийн  
 Өргөн чөлөө. Засгийн газрын XIV байр  
 Утас: 70041371  
 Факс: 70043467  
 И-мэйл:ndc@ndc.energy.mn

Захиалагчийн хаяг:

14241.Улаанбаатр хот  
 Сүхбаатар дүүрэг, 1-р хороо  
 Чингисийн өргөн чөлөө-24. “Парк  
 Плэйс” оффис, 3-н давхар.  
 Утас: 11-315144  
 И-мэйл:info@bodigroup.mn

Нэмэлт ажил үйлчилгээний 2022 оны 04 сарын 27-ний өдрийн  
 “НАУ-РХАА 2022-20” тоот гэрээний хавсралт 1.....



“Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд баригдах “Тавантолгой-Оюутолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын цахилгаан хангамжийг 35 кВ-ын шугам, дэд станцаар Төвийн эрчим хүчний системтэй холбох үеийн реле хамгаалалтын тооцоог гүйцэтгэх ажлын задаргаа


2022-04-20


№	Үндсэн агуулга	Гүйцэтгэх ажил, тооцоо, судалгаа	Үнийн дүн, мян/төгрөг
1	Өгөгдөл бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Тооцооны схем, өгөгдөл бүрдүүлэх</li> <li>Сонгосон тоноглолын техникийн өгөгдлийг тооцооны өгөгдөлд хөрвүүлэх</li> <li>Тооцооны схемийг горимын тооцооны дагуу боловсруулах</li> </ul>	100.00
2	Суурь тооцоотой холбоотой үндсэн судалгаа	<ul style="list-style-type: none"> <li>Горимын тооцооны судалгаа</li> <li>Төмөр замын цахилгаан хангамжийн зураг схем судалгаа</li> <li>Эх үүсвэр талын дэд станцуудын реле хамгаалалтын тавилын зохицуулалт, судалгаа,</li> </ul>	100.00
3	Программд оруулж, нягтлах, богино залгааны тооцоо хийх	<ul style="list-style-type: none"> <li>Шинэ тоноглолын мэдээллийг оруулах, тооцооны программд хөрвүүлж орлуулгын схем боловсруулж, өгөгдөл оруулж нягтлах</li> <li>Өгөгдөлийг нягтлаж, программын ажиллах боломжийг шалгах</li> <li>Системийн минимум, максимумын горимд богино залгааны гүйдлийн тооцоо гүйцэтгэх</li> </ul>	600.00
4	Эх үүсгүүр талын дэд станц, шугамын реле хамгаалалтын тавилын тооцоо хийх	<ul style="list-style-type: none"> <li>220/22/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцаас холбогдох 35 кВ-ын Зэрэглээ-А,Б шугамын реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> <li>220/22/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцын хүчний трансформатор болон 35 кВ-ын нийт холболтуудын реле хамгаалалт шалгаж, зохицуулалт хийх</li> </ul>	2,000.00
		<ul style="list-style-type: none"> <li>220/22/35 кВ-ын Оюутолгой дэд станцаас холбогдох 35 кВ-ын Манхан-А,Б шугамын реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> <li>220/22/35/10 кВ-ын Оюутолгой дэд станцын хүчний трансформатор болон 35 кВ-ын нийт холболтуудын реле хамгаалалт шалгаж, зохицуулалт хийх</li> </ul>	2,000.00
5	Төмөр замын 35 кВ-ын дэд станц, шугамуудын реле хамгаалалтын тооцоо хийх	<ul style="list-style-type: none"> <li>35/10 кВ-ын 2x2000 кВА чадалтай Зэрэглээ дэд станцын реле хамгаалалтын иж бүрэн тооцоо хийх</li> </ul>	2,000.00
		<ul style="list-style-type: none"> <li>35/10 кВ-ын Зэрэглээ дэд станцад холбогдсон Зэрэглээ-А,Б шугамын реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00
		<ul style="list-style-type: none"> <li>35/10 кВ-ын Зэрэглээ дэд станцад холбогдсон Зөрлөг-А,Б шугамын реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00
		<ul style="list-style-type: none"> <li>35/0,4 кВ-ын Манхан дэд станцад холбогдсон Манхан-А,Б шугамын реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00




	<ul style="list-style-type: none"> <li>35/0,4 кВ-ын Манхан дэд станцад холбогдсон Зөрлөг-А,Б шугамын реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00
	<ul style="list-style-type: none"> <li>35/0,4 кВ-ын Манхан дэд станцад холбогдсон Гашуунсухайт-А,Б шугамын реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00
	<ul style="list-style-type: none"> <li>35/10 кВ-ын 2х1250 кВА чадалтай Гашуунсухайт дэд станцын реле хамгаалалтын иж бүрэн тооцоо хийх</li> </ul>	2,000.00
	<ul style="list-style-type: none"> <li>35/10 кВ-ын Гашуунсухайт дэд станцад холбогдсон 35 кВ-ын Гашуунсухайт-А,Б шугамын реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00
	<ul style="list-style-type: none"> <li>35 кВ-ын Салбар-1, Зөрлөг-4 шугамын реклоузериин салбар пунктийн реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00
	<ul style="list-style-type: none"> <li>35 кВ-ын Зөрлөг-4, Гашуунсухайт шугамын реклоузериин салбар пунктийн реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00
	<ul style="list-style-type: none"> <li>35 кВ-ын шугамын АТ1, 2 реклоузериин пунктийн реле хамгаалалтын тавилыг шинээр тооцоолох</li> </ul>	2,000.00
6	Тооцоо хүргүүлэх	-
	<ul style="list-style-type: none"> <li>Тооцоог хүргүүлэх</li> </ul>	
	Үнэлгээ	26,800.00
	НӨАТ	2,680.00
	Нийт үнэлгээ	29,480.00


Хянасан:


Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер  Б. Баатар

Реле хамгаалалтын албаны дарга  Ч. Амарсанаа -г

Реле хамгаалалтын албаны ахлах инженер  Ч. Мөнх-Эрдэнэ

Боловсруулсан:

РХТТХ-ийн ахлах инженер  Д.Цоож

РХАА-ны инженер  Л.Батжаргал